

1. Ээлжит хичээлийн бүртгэл


Аль бүлэгт, хэн багш, ямар хичээлийг, аль танхимд, ямар хуваариар хичээллэхийг бүртгэснийг "**Ээлжит хичээлийн бүртгэл**" гэж БСМС -д ойлгоно.

Хуваарь* гэдэг нь: Тухайн хичээлийг аль улиралд, хэддүгээр ээлжинд, долоо хоногт хэдэн удаа, ямар гарагт, хэддүгээр цагт хичээллэх бүртгэл юм.

Ээлжит хичээл бүртэх видео үзэх бол дараах холбоос дээр дарна уу.

<https://www.youtube.com/watch?v=yvEG-6ZcJP0>

Ээлжит хичээлийн бүртгэл нь **Үндсэн бүртгэл** болон **Хуваарийн бүртгэл** гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.



№	Хичээл	Хичээлийн төрөл	Багш	Ээлжит хичээл	Төлөв	Хуваарь
1	Монгол хэл 1 (МХЛ 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	МХЛ 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах
2	Математик 1 (МАТ 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	МАТ 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах
3	Биеийн тамир 1 (БНТ 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	БНТ 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах
4	Дүрслэх урлаг Технологи 1 (ДУТ 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	ДУТ 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах
5	Хөгжим 1 (ХӨГ 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	ХӨГ 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах
6	Бэлтгэл хичээл 1 (БЭХ 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	БЭХ 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах
7	Хүн ба орчин 1 (ХБО 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	ХБО 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах
8	Иргэний ёс зүйн боловсрол 1 (ИБЛ 01101) Заавал	Үндсэн бүлэг	Б.Өлзийбаяр	ИБЛ 1-а	🟢 Батлагдсан	🔗 Хуваарь засварлах

Ээлжит хичээлийн бүртгэлийг **Анги удирдсан багш** эсвэл **Сургалтын менежер** бүртгэнэ.

Хэрэв Анги удирдсан багш ээлжит хичээлийн бүртгэл хийсэн бол Сургалтын менежер **Баталгаажуулалт** хийх шаардлагатай.

Сургалтын менежер **Ээлжит хичээлүүдийг** баталгаажуулсанаар хичээл заадаг багш **Цахим журнал хөтлөх** боломжтой болно.

Ээлжит хичээл үүсгэх төрөл:

Ээлжит хичээлийн бүртгэл
✕

–Хичээлийн төрөл–

–Хичээлийн төрөл–

Үндсэн бүлэг

Дэд бүлэг

–Хичээл–

Улирал

1-р улирал
 2-р улирал
 3-р улирал

Бүлэг

№	Хичээл	Ээлжит хичээл	Товч нэр	Багш	Танхим
Мэдээлэл байхгүй					

Болих

✓ Хадгалах

Үндсэн бүлэг: Анги нийтээрээ орох хичээлийг тухайн төрлийг сонгож ээлжит хичээл үүсгэнэ.

Жишээ нь: Монгол хэл 7 /заавал хичээл/ бүх суралцагч судлах ёстой.

Дэд бүлэг: Нэг бүлгийн суралцагчдийг дэд бүлэг болгон хувааж ордог хичээлийн тухайн төрлийг сонгож ээлжит хичээл үүсгэнэ.

Жишээ нь: Технологийн хичээлийг эрэгтэй, эмэгтэй суралцагчаар хуваагдаж ордог бол Технологи 7-а /эр/, Технологи 7-а /эм/ үүсгэнэ.

Хичээлийн бүлэг: Олон бүлэгт нэг болон олон хичээлийг нэг хуваариар хичээллэж буй бол тухайн төрлийг сургалтын менежер ээлжит хичээлийг үүсгэнэ.

Ээлжит х